



АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 1100

Улаанбаатар хот

Үйлчилгээний цагийн хуваарийг  
шинэчлэн батлах тухай

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/105 дугаар "Улаанбаатар хотод ажил эхлэх цагийг өөрчлөх тухай" захирамж, тус үндэсний төвийн дүрмийн 6.8 дахь хэсэг, Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүн дэд захирлын 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн шуурхай зөвлөгөөний тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын "Баянзүрх", "Сонгинохайрхан", "Баянгол" салбаруудын техникийн хяналтын үзлэг хийх цагийн хуваарийг 1 дүгээр хавсралтаар, Тээврийн хэрэгслийн бүртгэлийн ажиллах цагийн хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс мөрдөж ажиллуулсугай.

2. Энэхүү тушаалыг дагаж мөрдөн, хэрэгжүүлж ажиллахыг Техникийн хяналтын хэлтэс /С.Насанбат/, Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтэс /Б.Энхцэцэг/ болон холбогдох Салбарын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Н.Зориг/, Захиргаа, удирдлагын хэлтэс /М.Мөнхбаяр/ нарт даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Захирлын 2014 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн "Улаанбаатар хот дахь салбаруудад техникийн хяналтын үзлэг хийх цагийн хуваарийг батлах тухай" 03 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ



Н.ПУНЦАГ

000060

Автотээврийн үндэсний төвийн захирлын үүргийг  
түр орлон гүйцэтгэгч, тэрвүүн дэд захирлын  
2015 оны *04* дугаар сарын *19*-ний өдрийн  
*1/20* дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ХИЙХ ЦАГИЙН ХУВААРЬ

№	Салбарын нэр	Ажлын өдрүүдэд ажиллах цаг	Бямба, Ням гаригт ажиллах цаг
1	Баянзүрх салбар	08:30-20:30	09:00-19:00
2	Сонгинохайрхан салбар	08:30-20:30	09:00-19:00
3	Баянгол салбар	08:30-20:30	09:00-19:00

-----oO-----